



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/443

Мөрөн сум

Шинэ жилийн баяртай холбогдуулан авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар хурлын тэмдэглэлийг харгалзан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний албан тушаалтнууд төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баярын арга хэмжээ зохион байгуулахыг аймгийн хэмжээнд хориглосугай.

2. Аймгийн хэмжээнд шинэ жилийн баярыг архигүй тэмдэглэхийг нийт ард иргэд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.

3. Аймгийн хэмжээнд шинэ жилийн баярын үеэр иргэд архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас гэмт хэрэг, зөрчилд холбогдох, иргэн осгох, хөлдөхөөс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа А.Алтанцоож)-т үүрэг болгосугай.

4. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Захирамж-2022

6712911731